



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 05 онд

Дугаар 9/294

Мандалговь

Г  
Өмнө нь гэр булийн хэрэгцээнд дундаа хамtran  
өмчилсөн газрыг гэр булийн нэг гишиүүнд  
шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 5 дугаар сарын 1-ээс өмнө гэр булийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр булийн гишиүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 7 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 88 дүгээр захирамжийн хавсралтын 11, 2008 оны 264 дүгээр захирамжийн хавсралтын 15, 2006 оны 10 дүгээр захирамжийн хавсралтын 14, 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 511, 1080, 952, 2008 оны 150 дүгээр захирамжийн хавсралтын 36 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Хамtran өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ здлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

02000236